



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”

ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027

Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,

Цахим шуудан: info@erdenetmc.mn,

Цахим хаяг: www.erdenetmc.mn

᠒᠐24-12-10 № ᠐᠑-᠓2-1᠒/᠒᠒᠒᠒
танай _____ -ны № _____ -т

ӨНДӨР ДАРАЛТЫН БОЛОН ШУГАМЫН ГАН ХООЛОЙ НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

Захиалагчийн шийдвэр гаргах хугацааг
сунгах тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан “Өндөр даралтын болон шугамын ган хоолой” нийлүүлэх ЭҮТӨҮГ/20240102142 дугаартай тендерт оролцсон Шинэ-Инж ХХК болон ТМ ареа ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, Сангийн яамны 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам” (цаашид “журам” гэх)-ын 4.1-д заасны дагуу гомдол гаргасан.

Тус гомдлын дагуу Сангийн яамны 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 03/10050 дугаар, 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 03/10051 дүгээр албан бичгээр Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын 5.9-т заасныг хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээ авах гэсэн шийдвэр гаргасан тул хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг үндэслэн захиалагчийн шийдвэр гаргах хугацааг ажлын 15 хоногийн хугацаагаар сунгаж байгааг мэдэгдье.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН
АВАХ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГА



С.ЭНХМАНДАХ

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

612407038972